



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/27

Шивээговь сум

Ажил зохион байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, Аймгийн Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэр, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 04 дүгээр хуралдааны 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улс орон даяар өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл байдлыг хангах, Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөц сангаас овъёос, буудай малчдад үнэгүй олгох шийдвэрийн хүрээнд тусламжийг татан авах, тараан олгох ажлыг чанартай зохион байгуулсугай.

2. Овъёос буудай татан авах, ачих буулгах ажилд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тусламжаар олгогдож буй овъёос, буудайг татан авах, тараан олгох ажилд зарцуулагдах 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.


4. Тус ажлыг чанартай зохион байгуулж, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Бадамханд), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар
сарын 12-ны өдрийн 1127 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССООС ОЛГОЖ БУЙ БУДАА,
ОВЪЁОС ТАТАН АВАХ, ТАРААХ АЖИЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	Шатахууны зардал	200,000	Будаа ачих, буулгах, хүлээн авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн албан хаагчдыг зөөвөрлөх машины шатахуун, тосолгоонд
2	Ажил гүйцэтгэх гэрээ	1,000,000	Будаа, овъёосыг тээвэрлэх ажлыг зохион байгуулсны хөлсөнд
НИЙТ ДҮН		1,200,000	

----- 000 -----